

Монгол Улс

Монгол Улсад Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл (P173799).

[Хэлэлцээрт зориулсан ноорог хувилбар]

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ТАЛААРХИ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ТАЛААРХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. **Монгол Улс** (цаашид Зээлдэгч / Хүлээн авагч) нь Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-г оролцуулан “Монгол Улсад Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл (Төсөл) хэрэгжүүлнэ. Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк, Олон улсын хөгжлийн ассоциаци (Цаашид Банк / ассоциаци) төслийг санхүүжүүлэхээр тохиролцов.
2. Зээлдэгч / Хүлээн авагч нь материаллаг арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Тийм учраас төслийг Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС) -ийн дагуу хэрэгжүүлнэ. Байгаль орчин, нийгмийн талаархи үүрэг хариуцлагын төлөвлөгөө (БОНҮХТ) нь бодит арга хэмжээ, үйл ажиллагаа, аливаа тодорхой баримт бичиг, төлөвлөгөө, түүнчлэн эдгээрийн цаг хугацааг тусгасан.
3. Дээрх 1-р хэсэгт заасан яамны хэрэгжүүлэх бодит арга хэмжээ, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад Зээлдэгч / Хүлээн авагч байгаль орчин, нийгмийн талаархи үүрэг хариуцлагын төлөвлөгөөний бүх шаардлагуудыг биелүүлэх үүрэгтэй.
4. Зээлдэгч / Хүлээн авагч нь байгаль орчин, нийгмийн талаархи үүрэг хариуцлагын тус төлөвлөгөөнд тусгасан бодит арга хэмжээ болон үйл ажиллагааны хэрэгжилтэд тус төлөвлөгөөнд тусгасан шаардлага, хууль ёсны гэрээний нөхцлийн дагуу хяналт тавьж Банк / ассоциацид тайлагнана. Ассоциаци нь төслийн хэрэгжилтийн явцад бодит арга хэмжээ, үйл ажиллагааны явц, гүйцэтгэлд хяналт тавьж, үнэлнэ.
5. Төслийн өөрчлөлт, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдалд зохицуулах асуудлыг тусгах, эсхүл Байгаль орчин, нийгмийн талаархи үүрэг хариуцлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд төслийн гүйцэтгэлийг үнэлэхэд хариу өгөх зорилгоор Банк / ассоциаци болон Зээлдэгч / Хүлээн авагч тохиролцсоны дагуу байгаль орчин, нийгмийн талаархи үүрэг хариуцлагын төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэх явцад шинэчилж болно. Ийм нөхцөл байдалд Зээлдэгч / Хүлээн авагч ЭМЯ-аар дамжуулан Банк / ассоциацитай өөрчлөлтүүдийг тохиролцох бөгөөд байгаль орчин, нийгмийн талаархи үүрэг хариуцлагын төлөвлөгөөнд эдгээр өөрчлөлтийг тусгаж шинэчлэнэ. Байгаль орчин нийгмийн талаархи үүрэг хариуцлагын төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлтийн гэрээг ЭМЯ-р дамжуулан Банк / ассоциаци болон Зээлдэгч / Хүлээн авагч хооронд гарын үсэг бүхий захидал солилцоно. Зээлдэгч / Хүлээн авагч нь ЭМЯ-р дамжуулан шинэчилсэн Байгаль орчин, нийгмийн үүрэг хариуцлагын төлөвлөгөөг нэн дариу ил тод олон нийтэд мэдээлнэ.
6. Төслийн өөрчлөлт, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал эсхүл төслийн хэрэгжилтийн явцад төслийн гүйцэтгэлийн үр дүнгийн эрсдэл, үр нөлөөллийн өөрчлөлтүүдийн үед Зээлдэгч / Хүлээн авагч тал шаардлагатай бол ийм эрсдэл, нөлөөллийг арилгах арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нэмэлт санхүүжилт олгоно.

БОДИТ АРГА ХЭМЖЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГАА		Хугацаа	Хариуцах эрх бүхий байгууллага/ аж ахуйн нэгж
ХЯНАЛТ БОЛОН ТАЙЛАГНАЛТ			
А	АЛБАН ЁСНЫ ТАЙЛАН: Төслийн гүйцэтгэлийн байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны, оролцогч талуудын оролцоо, өрөгдөл гомдлын бүртгэл зэрэгт хяналт, шинжилгээг тогтмол хийж тайлан бэлтгэн Банк / ассоциацид хүргүүлнэ.	Төслийн хэрэгжилтийн хугацаанд улирлаар	ЭМЯ/ТХН
БОНС 1: Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ, менежмент			
1.1	<p>БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ: Төслийн байгаль орчин нийгмийн талаархи үүрэг хариуцлагын төлөвлөгөөний менежментэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Цахим эрүүл мэнд төслийн нэгжийг дараахь мэргэжилтэнүүдээр бэхжүүлэх.</p> <p>Үүнд: (i) био-эмийн инженер (ii) хүрээлэн буй орчин болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэргэжилтэн ; (iii) эрсдэл болон олон нийттэй харилцах мэргэжилтэн.</p>	<p>Төслийн үндсэн бүрэлдэхүүнийг төсөл хэрэгжүүлж эхлэхээс өмнө томилох бөгөөд төслийн хэрэгжилтийн хугацааны туршид ажиллуулна.</p> <p>(i) Эрсдлийн болон олон нийттэй харилцах мэргэжилтэн</p> <p>(ii) Эмнэлэгийн тоног төхөөрөмж мэргэжилтэн</p> <p>(iii) Хүрээлэн буй орчны хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн</p>	ЭМЯ/ТХН

1.2	<p>БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГЭРЭЭ БАРИМТ БИЧИГ/ ГЭРЭЭЛЭГЧ</p> <p>a. Санал болгож буй төслийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээг төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэхээс өмнө Банк / ассоциацид хүлээн зөвшөөрөх арга хэлбэр, агуулгаар Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөний (ESMP) дагуу төсөлд зориулан бэлтгэнэ. Байгаль орчин, нийгмийн удирдлагын тус төлөвлөгөө нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан орхигдож болзошгүй эсхүл эмзэг бүлгийн хувь хүн, бүлгүүд төслийн үр дүнд бий болох хөгжлийн үр шимийг хүртэх арга хэмжээг тусгана.</p> <p>b. Үнэлгээнд тулгуурлан байгаль орчин, нийгмийн удирдлагын аливаа төлөвлөгөө эсхүл төслийн үйл ажиллагаатай холбоотой бусад шаардлагатай баримт бичгийг Байгаль орчин, нийгмийн стандартууд, Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамжууд болон бусад Аж үйлдвэрийн олон улсын сайн туршлага (GIP), ДЭМБ-ын Эрсдэлийн үеийн олон нийттэй харилцах харилцаа, олон нийтийн оролцоо, шилжин суурьшигчдын бааз хуаран, тохирох бааз хуарангийн удирдамжууд, сургуулиуд, ажлын байр болон байгууллагуудын удирдамж, амьтнаас хүнд халдварлах халдварыг бууруулах, халдвараас хамгаалах, хянах /WASH удирдамж, Үндэсний лабораториудын удирдамжийн дагуу Банк / ассоциацид хүлээн зөвшөөрөх арга хэлбэрээр бэлтгэж, мэдээлж, баталж хэрэгжүүлнэ.</p> <p>c. Байгаль орчин нийгмийн талаархи үүрэг хариуцлагын тус төлөвлөгөөнд хамааралтай асуудлыг тухайлбал байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (ESMP) эсхүл бусад баримт бичиг, Байгаль орчин нийгмийн стандарт(БОНС)-2, бусад шаардлагатай байгаль орчин нийгмийн арга хэмжээнүүдийг худалдан авах ажиллагааны баримт бичгийн байгаль орчин нийгэм, эрүүл мэндийн стандартын заалт мөн гэрээт байгууллагууд болон хяналт тавьдаг компаниудтай байгуулсан гэрээнд тусгах. Үүний дараа гүйцэтгэгч болон хяналт тавьдаг компаниуд тус тусын гэрээний байгаль орчин нийгэм, эрүүл мэндийн стандартын заалтын биелэлтийг хангаж ажиллана.</p>	<p>a. Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөг төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө бэлтгэж боловсруулна. Төслийн холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэхээс өмнө үнэлгээ хийнэ.</p> <p>b. Төслийн холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэхээс өмнө болон дараа эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</p> <p>c. Төслийн холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэхээс өмнө болон дараа эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</p>	ЭМЯ/ТХН
-----	--	---	---------

БОДИТ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА		Хугацаа	Хариуцах аж ахуйн нэгж/эрх бүхий байгууллага
1.3	<p>Хориглох үйл ажиллагаа: Дараахь төрлийн үйл ажиллагааг төсөл санхүүжүүлэхгүй:</p> <ul style="list-style-type: none"> • Урт хугацааны, байнгын эсвэл эргэлт буцалтгүйгээр (жишээлбэл, байгалийн цөм амьдрах орчныг устгах) сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй үйл ажиллагаа; • Ковид-19 тохиолдлыг эмчлэхээс бусад тохиолдолд хүний эрүүл мэнд эсхүл хүрээлэн буй орчин байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх өндөр магадлалтай үйл ажиллагаа; • Нийгэмд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй, нийгмийн зөрчилдөөнд хүргэж болзошгүй үйл ажиллагаа; • Нутгийн иргэд эсхүл эмзэг бүлгийн цөөнхийн газар нутаг, эрхэнд нөлөөлж болзошгүй үйл ажиллагаа; • Бүр мөсөн нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлөх эсхүл соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа • Төслийн байгаль орчин, нийгмийн талаархи үүрэг хариуцлагын төлөвлөгөөнд тусгаагүй бусад бүх үйл ажиллагаа 	Эдгээр хориглосон үйл ажиллагаануудыг үйл ажиллагаа 1.2.а –гийн хүрээнд зохион байгуулах үнэлгээний үйл явцын хэсэг гэж үзэж ашиглана.	ЭМЯ/ТХН
БОНС 2: АЖИЛЛАХ ХҮЧ БОЛОН АЖЛЫН НӨХЦӨЛ			
2.1	<p>АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УДИРДЛАГА: Төсөл нь БОНС2 шаардлагын дагуу Ассоциаци хүлээн зөвшөөрөх арга хэлбэрээр тухайлбал хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны зохих арга хэмжээг хэрэгжүүлэх (яаралтай тусламжийн бэлэн байдал, хариу арга хэмжээг оролцуулан), төслийн ажилчдын гомдлыг зохицуулах арга хэмжээг тогтоох, хөдөлмөрийн шаардлагыг худалдан авах ажиллагааны баримт бичгийн байгаль орчин нийгэм, эрүүл мэндийн стандартын заалт , гэрээт байгууллагууд болон хяналт тавьдаг компаниудтай байгуулсан гэрээнд тус тус тусгах ажлыг зохион байгуулна.</p>	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	ЭМЯ
2.2	<p>Зээлдэгч/ Хүлээн авагч нь ажиллах хүчний удирдлагын төлөвлөгөөг Банк/Ассоциаци хүлээн зөвшөөрөх арга хэлбэрээр бэлтгэн боловсруулж, баталж, хэрэгжүүлнэ.</p>	Ажиллах хүчний удирдлагын төлөвлөгөөг төслийн үйл ажиллагаанд төслийн ажилчид оролцож эхлэхээс өмнө баталж төсөл хэрэгжүүлэх хугацаанд мөрдөж ажиллана.	ЭМЯ

БОДИТ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА		Хугацаа	Хариуцах аж ахуйн нэгж/эрх бүхий байгууллага
2.3	Зээлдэгч/ Хүлээн авагч нь БОНС 2 болон байгаль орчин нийгэм, эрүүл мэндийн стандартууд мөн ДЭМБ-ын баталсан Ковид-19 н үед лабораторийн, хорио цээрийн болон тусгаарлах төвүүд, шалгах цэгүүдэд ашиглах тоног төхөөрөмжийн удирдамж зэрэг Аж үйлдвэрийн олон улсын сайн туршлага (GIIP) –тай холбоотой удирдамжуудын шаардлагад нийцүүлэн хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны зохих арга хэмжээг (яаралтай тусламжийн бэлэн байдал, хариу арга хэмжээг оролцуулан) байгаль орчин, нийгмийн үүрэг хариуцлагын төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлнэ.	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	ЭМЯ
2.4	Зээлдэгч/ Хүлээн авагч нь эрүүл мэндийн бүх ажилтнууд ДЭМБ-ын ёс зүйн дүрэм, мэргэжлийн хэм хэмжээг дагаж мөрдөхийг хангаж ажиллана.	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	ЭМЯ/ТХН
2.5	Зээлдэгч/ Хүлээн авагч нь Өрөгдөл гомдол барагдуулах механизм бий болгож, эдгээр гомдлыг барагдуулах ажилтнуудыг ЭМЯ/ТХН-нд томилж ажиллуулна.	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	ЭМЯ/ТХН
2.6	Зээлдэгч/ Хүлээн авагч нь хөдөлмөрийн хортой нөхцөл байдлаас шалтгаалан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг /18-аас доош насны/ хориглоно.	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	ЭМЯ/ТХН
БОНС 3: НӨӨЦИЙН ҮР АШИГ , БОХИРДЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОЛОН МЕНЕЖМЕНТ			
3.1	Шаардлагатай бол энэ стандартад хамааралтай асуудлуудыг үйл ажиллагаа 1.2 хүрээнд авч үзнэ.		
БОНС 4: ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ			
4.1	Шаардлагатай бол энэ стандартад хамааралтай асуудлуудыг үйл ажиллагаа 1.2 хүрээнд авч үзнэ.		
БОНС 5: ГАЗАР ЧӨЛӨӨЛӨХ МӨН ГАЗАР АШИГЛАХ БОЛОН АЛБАДАН НҮҮЛГЭХ ХЯЗГААРЛАЛТУУД			
5.1	Шаардлагатай бол энэ стандартад хамааралтай асуудлуудыг үйл ажиллагаа 1.2 хүрээнд авч үзнэ.	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	ЭМЯ/ТХН
5.2	Төсөл нүүлгэн шилжүүлэх болон газар чөлөөлөх үйл ажиллагаанд оролцохгүй.Газар чөлөөлөх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд аливаа газар чөлөөлөх үйл ажиллагаа эхлэхээс өмнө БОНС 5 -ийн дагуу, Банк/ ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх төлөвлөгөөг боловсруулсан байна.	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	ЭМЯ/ТХН
БОНС 6: БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛАЛ БОЛОН АМЬД БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТ			
	Хамааралгүй		
БОНС 7: НУТГИЙН ИРГЭД /АФРИКИЙН САХАР ОРЧМЫН БУС НУТГИЙН НУТГИЙН ИРГЭД			
	Шаардлагатай бол энэ стандартад хамааралтай асуудлуудыг үйл ажиллагаа 1.2 хүрээнд авч үзнэ.		

БОДИТ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА		Хугацаа	Хариуцах аж ахуйн нэгж/эрх бүхий байгууллага
БОНС 8: СОЁЛЫН ӨВ			
	Шаардлагатай бол энэ стандартад хамааралтай асуудлуудыг үйл ажиллагаа 1.2 хүрээнд авч үзнэ.		
БОНС 9: САНХҮҮГИЙН ДҮРЭМ			
	Хамааралгүй		
БОНС 10: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО БОЛОН МЭДЭЭЛЭЛ ИЛ ТОД БОЛГОХ			
10.1	ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ: Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөөг БОНС 10 т нийцсэн Банк/ ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх арга хэлбэрээр шинэчилж, мэдээлж, баталж хэрэгжүүлнэ.	Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөөний төслийг боловсруулсан бөгөөд төслийн хэрэгжилтийн хүчин төгөлдөр огноогоос хойш 30 хоногоос хэтрэхгүй хугацаанд шинэчилж олон нийтэд мэдээлнэ. Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэх хугацаанд хэрэгжүүлнэ.	ЭМЯ/ТХН
10.2	ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ : Төсөлтэй холбоотой асуудал, гомдлыг шийдвэрлэх, хөнгөвчлөх зорилгоор гомдол барагдуулах хүртээмжтэй зохицуулалтыг БОНС 10 нийцүүлэн, Банк/ ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх арга хэлбэрээр олон нийтэд нээлттэй болгох	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	ЭМЯ/ТХН
ЧАДАВХИ БЭХЖҮҮЛЭХ (СУРГАЛТ)			
	Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд оролцох ажилтнуудад зориулсан сургалтын сэдвүүд дараахь асуудлуудыг багтаана: <ul style="list-style-type: none"> • Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хянах зөвлөмж лабораторийн биоаюулгүй байдлын Ковид-19 тэй холбоотой удирдамж • Сорьц цуглуулах, зөөвөрлөх • Ковид 19 халдвартай өвчинтөнд зориулсан стандарт сануулга/сэрэмжлүүлэг • Эрсдлийн үеийн олон нийттэй харилцах харилцаа, олон нийтийн оролцоо • Эмнэлэгийн болон аюултай хог хаягдын менежмент 	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	ЭМЯ/ТХН

